

Засгийн газрын 2020 оны .... сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ТӨРӨЛ БҮРИЙН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС,  
БАЙРШЛЫГ ТОГТООХ ЖУРАМ**

***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Баталгаажсан үүлдэр омгийн малыг дасан зохицсон болон ашиг шимээ бүрэн өгөх, хэвийн өсөж үржих боломжтой бүс нутагт үржүүлэх, сайжруулагчаар ашиглах, борлуулах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад журмын зорилго оршино.

1.2. Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжүүдэд энэ журам нэгэн адил хамаарна.

1.3. Тухайн бүс нутагт зөвшөөрөгдсөн үүлдэр омгийн малыг бойжуулж, үржүүлж борлуулах үйл ажиллагааг эрх бүхий этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

***Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа***

2.1. Энэхүү журмын хэрэгжилтийг аймаг, нийслэлийн ХХААГ-ын Мал үржлийн алба хариуцан зохион байгуулна.

Үржлийн малыг зөвхөн энэхүү журмаар зөвшөөрөгдсөн бүс нутагт үржүүлнэ.

2.2. Үржлийн мал өсгөн бойжуулж борлуулах иргэн, хуулийн этгээд, үржүүлэг технологийн нэгж нь зах зээлд борлуулахдаа зөвхөн зөвшөөрөгдсөн бүс нутагт нийлүүлсэн байна.

2.3. Зах зээлд үржлийн зориулалтаар борлуулж буй мал нь цөм сүргийн шаардлагыг хангасан, хувийн дугаартай, удам гарвал баталгаажсан байна.

***Гурав. Хяналт тавих***

3.1. Үүлдэр омгийн малыг үржүүлэх бүс байршлыг тогтоосон энхүү журмын хэрэгжилтэнд Мал үржлийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

3.2. Энэхүү журмыг зөрчигчдөд ”Малын генетик нөөцийн тухай” болон “Зөрчлийн болон зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Төсөл  
Засгийн газрын 2020 оны .... сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД САЙЖРУУЛАГЧААР АШИГЛАХ  
ҮҮЛДЭР ОМГИЙН МАЛ ҮРЖҮҮЛЭХ БҮСИЙН ЧИГЛЭЛ**

		Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Сайжруулагч буюу цөм сүргийн байршил	Үржүүлэх зохистой бүс нутаг	Тайлбар
1	Адуу	1. Монгол үүлдэр	Уналга-эдэлгээ, мах, сүү, хурд	Хөвсгөлийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Ханх сумаас бусад	Бүх нутгаар	
2		2. Галшар үүлдэр	Уналга эдэлгээ, хурд	Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг	Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгууд болон Хээрийн бүс	
3		3. Тэс үүлдэр	Хурд-уналга-эдэлгээ	Увс аймгийн Тэс, Зүүнговь, Баруунтуруун Завхан аймгийн Тэс, Баянхайрхан, Баянтэс	Увс, Завхан, Ховд аймаг болон Эх нууруудын хотгор	
4		4. Дархад омог	Уналга-эдэлгээ-мах	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Ханх	Тагийн болон тайгын бүслүүр	
5		5. Мянгад омог	Уналга-эдэлгээ-хурд	Ховд аймгийн Мянгад, Дарив	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нууруудын хотгор, Говийн бүс	
6		6. Өндөршил омог	Хурд-уналга-эдэлгээ	Дундговь Өндөршил	Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгууд болон Говь, хээрийн бүс	
7	Тэмээ	1. Монгол үүлдэр	Ноос-мах- уналга эдэлгээ	Өмнөговь аймаг, Баянхонгорын Богд, Шинэжинст, Говь-Алтайн Төгрөг, Шарга, Халиун сумаас бусад Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан болон Дундговь аймгийн Хулд сум болон бусад тэмээ үржүүлдэг бүх нутаг	Бүх нутгаар	

8		2. Төхөм Тунгалагийн хүрэн үүлдэр	Ноос-мах- уналга эдэлгээ	Говь-Алтай аймгийн Төгрөг, Шарга, Халиун	Эх нууруудын хотгор, Говийн алтайн бүс Зүүн 3 аймаг, Дорноговь, Дундговь, Төв, Өвөрхангай, Өмнөговь аймгаас бусад тэмээ үржүүлэх боломжтой бүх нутагт	
9		3. Ханын Хэцийн хүрэн үүлдэр	Ноос-мах- уналга эдэлгээ	Өмнөговь аймгийн Мандал- Овоо, Булган, Цогтцэций	Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь аймгууд болон Говь цөлийн бүс	
10		4. Галбын говийн улаан үүлдэр	Ноос-мах- уналга эдэлгээ	Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо	Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь аймгууд болон Говь цөлийн бүс	
11		5. Ламын гэгээний улаан үржлийн хэсэг	Сүү-ноос	Баянхонгор аймгийн Баянлиг, Богд, Баянговь, Жинст	Баянхонгор, Өвөрхангай, Говь- Алтай болон Говь цөлийн бүс	
12	Үхэр	1. Мөнгөл	Мах	Бүх нутаг	Бүх нутаг	
13		2. Сарлаг	Сүү-махны	Архангай аймгийн Тариат, Өвөрхангай аймгийн Уянга, Ховд аймгийн Мөст, Завхан Их- Уул	Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Завхан Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгууд болон Өндөр уул, хангайн бүс	
14		3. Сэлэнгэ үүлдэр	Мах	Булган аймгийн Сэлэнгэ	Булган, Архангай, Сэлэнгэ, Өвөрхангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
15		4. Дорнод Монголын улаан үүлдэр	Мах	Дорнод аймгийн Халхгол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгууд болон Хээрийн бүс	
16		5. Буган халиун үүлдрийн хэсэг	Сүү-махны	Төв аймгийн Батсүмбэр	Төв, Булган, Орхон, Сэлэнгэ аймгууд болон газар тариалангийн бүс нутаг	

17	Хонь	1. Монгол хонь	Мах-Өөхний Бүдүүн ноост	Төв аймгийн Баянцагаан, Дундговь аймгийн Эрдэнэдалай	Ой тайгаас бусад бүх нутгаар	
18		2. Барга үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Дорнод аймгийн Хөлөнбуйр	Дорнод, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгууд болон Хээрийн бүс	
19		3. Үзэмчин үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан	Сүхбаатар, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь зэрэг зүүн болон төвийн говь, хээрийн бүс	
20		4. Керей үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Баян-Өлгий аймгийн Дэлүүн	Баян-Өлгий, Ховд аймгийн Өндөр уулын бүс	
21		5. Байдраг үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Баянхонгор аймгийн Жаргалант	Сайжруулагчаар ашиглах боломжгүй	Тоо толгой цөөрсөн
22		6. Баяд үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас	Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Төв аймгууд болон Эх нууруудын хотгор, Говь хээрийн бүс	
23		7. Говь-Алтай үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Говь-Алтай аймгийн Бугат, Цээл, Төгрөг	Говь-Алтай, Баянхонгор аймгууд болон Их нууруудын хотгор ба Говийн алтай, Говийн бүс	
24		8. Дархад үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Хөвсгөлийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Ханх	Хөвсгөл, Архангай, Булган аймгууд болон Өндөр уул, таг, тайгын бүслүүр	
25		9. Сартуул үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Завхан аймгийн Эрдэнэхайрхан,	Завхан, Архангай, Орхон аймгууд болон Өндөр уул, Эх нуурын хотгор ба Говийн алтайн бүс	
26		10. Хангай үүлдэр	Ноосны чиглэлийн нарийн ноост	Сэлэнгэ Цагааннуур, Булган Бүрэгхангай	Ойт хээр, газар тариалангийн бүс нутаг	Тоо толгой цөөрсөн, цус сэлбэх шаардлагатай

27	11. Орхон үүлдэр	Ноосны чиглэлийн нарийвтар ноост	Сэлэнгэ аймгийн Орхон	Ойт хээр, газар тариалангийн бүс	Тоо толгой цөөрсөн, цус сэлбэх шаардлагатай
28	12. Сүмбэр үүлдэр	Арьсны чиглэл	Говьсүмбэр аймгийн Сүмбэр	Сайжруулагчаар ашиглах боломжгүй	Тоо толгой цөөрсөн, мөн арчилгаа, маллагааны өвөрмөц технологитой
29	13. Тал нутгийн цагаан үүлдэр	Ноосны чиглэлийн нарийвтар ноост	Хэнтий Хэрлэн, Мөрөн	Хээрийн бүс	Тоо толгой цөөрсөн, цус сэлбэх шаардлагатай
30	14. Тамир үүлдрийн хэсэг	Мах-ноосны	Архангай Ихтамир	Архангай аймаг болон Хангай, ойт хээрийн бүс	
31	15. Ерөө үүлдрийн хэсэг	Мах-ноосны	Сэлэнгэ Ерөө	Сэлэнгэ аймаг болон газар тариалангийн бүс	Тоо толгой цөөрсөн, цус сэлбэх шаардлагатай
32	16. Торгууд үүлдрийн хэсэг	Мах-Өөхний Бүдүүн ноост	Ховд аймгийн Булган	Ховд аймаг болон Говийн бүс	
33	17. Хотонт үржлийн хэсэг	Мах-ноосны	Архангай Хотонт	Архангай, Булган, Өвөрхангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
34	18. Алтанбулаг үржлийн хэсэг	Махны	Төв аймгийн Алтанбулаг	Төв, Дундговь, Өвөрхангай аймгууд болон Ойт хээр, хээрийн бүс	
35	19. Жаргалант үржлийн хэсэг	Мах-ноосны	Төв аймгийн Жаргалант	Сайжруулагчаар ашиглах боломжгүй	Тоо толгой цөөрсөн
36	20. Буриад омог	Мах-ноосны	Дорнод аймгийн Дашбалбар	Дорнод аймаг болон Хээрийн бүс	
37	21. Баянгол омог	Мах-ноосны	Өвөрхангай аймгийн Баянгол	Өвөрхангай, Дундговь аймгууд болон Хээрийн ба говийн бүс	

38		22. Сутай үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Ховд аймгийн Дарив	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нуурын хотгор ба Говийн бүс	
39		23. Цагаан-Уул үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Хөвсгөл аймгийн Цагаан-Уул	Хөвсгөл, Завхан, Архангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
40		24. Бүрэгхангай үржлийн хэсэг	Мах-ноосны	Булган аймгийн Бүрэгхангай	Булган, Архангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
41		25. Сайнцагаан омог	Мах-өөх-ноосны	Дундговь аймгийн Сайнцагаан	Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгууд болон Говийн бүс	
42	Ямаа	1. Монгол үүлдэр	Ноолуур	Бүх нутаг	Бүх нутгаар	
43		2. Уулын бор үүлдэр	Ноолуур	Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Баяннуур, Булган	Баян-Өлгий аймаг болон Өндөр уулын бүс	
44		3. Говь гурван сайхан үүлдэр	Ноолуур	Өмнөговь аймгийн Булган	Өмнөговь аймаг болон Говь, цөлийн бүс	
45		4. Алтайн улаан үүлдэр	Ноолуур	Ховд аймгийн Алтай, Үенч, Говь-Алтай аймгийн Бугат	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нуурын хотгор ба Говийн бүс	
46		5. Залаа жинст Эдрэн үүлдэр	Ноолуур	Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баян-Өндөр	Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь аймгууд болон Говь, цөлийн бүс	
47		6. Завхан буурал үүлдэр	Ноолуур	Завхан аймгийн Дөрвөлжин	Завхан аймаг болон Говийн бүс	
48		7. Эрчмийн хар үүлдэр	Ноолуур	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг	Хөвсгөл, Булган, Архангай, Завхан аймгууд болон Хангайн бүс	
49		8. Өлгийн улаан үүлдэр	Ноолуур	Увс аймгийн Өлгий, Наранбулаг	Увс, Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нууруудын хотгор, Говийн бүс	
50		9. Баяндэлгэрийн улаан үүлдэр	Ноолуур	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр	Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Төв аймгууд болон Говийн бүс	
51		10. Бөмбөгөрийн улаан омог	Ноолуур	Баянхонгор аймгийн Бөмбөгөр	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгууд болон Говь, хээрийн бүс	
52		11. Галшарын улаан омог	Ноолуур	Хэнтий аймгийн Галшар	Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгууд болон Говь, хээрийн бүс	

53		12. Өнжүүл үржлийн хэсэг	Ноосны	Төв аймгийн Өнжүүл	Сайжруулагчаар ашиглах боломжгүй	Тоо толгой цөөрсөн, цус сэлбэх шаардлагатай
54		13. Дэлгэрэхийн улаан омог	Ноолуур	Дорноговь аймгийн Дэлгэрэх	Дорноговь, Дундговь аймгууд болон Говийн бүс	